

СО БАГШИЙН ТУХАЙ ХОЁР БЯЦХАН ДУРСАМЖ

Дэд проф. Ш.Чадраабал
ШУТИС-ийн Материал Технологийн Сургуулийн багш

Ерөөс Со багшийг мэдэхгүй хүн Монголд ховор биз гэж би боддог. Со багш бол хар багаасаа эрдэм соёлын мөр хөөн, насан туршдаа эх орондоо орчин үеийн боловсрол, шинжлэх ухааныг хөгжлүүлэхэд нөр их хувь нэмрээ оруулсан манай нэрт эрдэмтэн багш, олон нийтийн зүтгэлтэн хүн билээ. Түүний хийж бүтээсэн нь асар их, үйл ажиллагаа нь өргөн цар хүрээтэй, олон талтай байсан нь тодорхой. Үүнийг олон хүн сайн мэдэх байх. Харин би үүнийг Со багшийг Физик Технологийн Хүрээлэнд байхад шинжлэх ухааны гавъяат ажилтан цолд дэвшүүлэх болж тодорхойлолт баримтыг нь бүрдүүлэхэд намтар түүх, хийсэн бүтээснийг нь хоёр гурван удаа өөрөөр нь яриулж авсны дараа бүр сайн ойлгох болж, улам биширч, хүндэлж явах болсон юм. Тэгэхлээр Со багшийн олон олон шавь нар, хамтран зүтгэгсэд, найз нөхөд болон эрдэмтэн судлаачид үнэн түүхийг нь бичиж 20-р зууны Монголын энэ их соён гэгээрүүлэгч хүний жинхэнэ дүр төрхийг бүтээж, хойч үедээ үлдээх буй за. Би бол өнөөдөр Со багшийн энэхүү хөрөгт өчүүхэн нарийн зураас төдий болов ч нэмэр болох болов уу гэсэн сэтгэлийн үүднээс хоёр бяцхан баримтыг нь та бүхнээ толилуулъя гэсэн юм.

НЭГ ДЭХ ДУРСАМЖ

Нэг үе манай хатуу биеийн физикчид, цөмийн физикчид бидний дунд хатуу биеийн физик, цөмийн физик хоёрыг яаж холбох вэ? хатуу биеийн физикт цөмийн физикийн аргуудыг хэрхэн хэрэглэх вэ? гэж багагүй ярилцдаг, зарим нэг санаа оноо гаргадаг байлаа. Гэтэл Микротрон хурдасгуурыг манайд байгуулах ажил эхлээд барилгын ажил энээ тэрээ саад тотгор учран ашиглалтанд орох хугацаа байн байн хойшилж сунаж байх хооронд бид микротрон дээр хатуу биеийн физикийн ямар судалгаа хийх вэ? гэж нилээд яриа хөөрөө болдог байв.

Со багш бид нар энэ талаар хэд хэдэн удаа ярилцаж зарим нэг судалгааг явуулах нь зүйтэй гэж үзсэн юм. Со багштай нэг удаа уулзахад "Радиацийн технологи" гэдэг төсөл хэрэгжүүлэх болсноо яриад үүнд намайг оролцож, радиацийн технологийн хөгжлийн төлөв байдал, радиацийн технологийг Монголд хэрэглэх талаар нэг тойм бичиж өгвөл зүгээр байна гэлээ. Би ч за гэсэн

боловч нэг мэдэхэд нилээн хугацаа өнгөрсөн байлаа. Нэг өдөр гадуур явж байгаад ирсэнд манай лабораторийнхан Со байр ирээд явсан, чамд бичиг орхиод явсан гэлээ. Уг бичгийг нь яг тэр хэвээр нь иш татъя.

*Радтех сэдвийн гишүүн хүндэт н. Ш.Чадраабалд
Радиацийн технологи, Радтех хэрэглэх боломжийн талаар
интернет ашиглаж зарим сэдвүүдээр мэдээ цуглуулна уу!*

1. Хүнс хадгалах РАДТЕХ хэрэглэж байгаа мэдээ. Энэ маш их тул тодорхой нэгэн зүйл заах. Ж нь мах? сүү? тодорхой ногоо? Өөрөө бодоорой.
2. Мод модон эдлэлийг үнэт төрлийн мод болгоход Радтех хэрэглэж буй мэдээ. Манай мебелийн үйлдвэрт хэрэглэж Барилгад үнэт модон жижиг хавтан хийх ...
3. Арьс ширийг хатаж авчихгүй болгох, гуужихгүй болгоход радтех хэрэглэсэн мэдээ байна уу.
4. Хулгана зурмын үрэлийг дарангуйлах радтех арга хэрэглэсэн мэдээ. Ж.нь Австралид туулайн үржлийг багасгахад хэрэглэдэг байж мэднэ.
5. Нэг удаагийн шприц, сахлын машин зэрэг барааг бактериомактеризэс ариутгах оновчтой тохиромжтой жишээ. Ийм мэдээ бас их байгаа.
6. Тарианы сүрлийг шарсан, урт молекулыг богино болгох таслахад радтех хэрэглэсэн жишээ.

Эдгээр болон өөр бодогдох тодорхой нэрээр, жилээр хязгаарлаж эрэхийг бодох. Ж.нь сүрлийг 1990 оноос хойш шарсан туршилтууд.

Эрэх материал бол ЭШ сэтгүүлийн статья, ном, патент...

Best regards Н.Содном

Энэ бичгийг аваад хэд хоног сууж нэг тойм бичив. Со багш уншиж үзээд тайландаа оруулахаар болов. Хэсэг хугацаа өнгөрсний дараа нэг өдөр төслийн мөнгөө аваарай гэж утасдаж байна.

Ум хумгүй Их Сургууль дээр давхиж ирж мөнгөө авбал хэд хэдэн хүн Со багш өөрт чинь мөнгө гаргуулах гэж яваад л байсан гэж хэлж билээ. Тэр үед мөнгө бүр ч ховор байсан цаг. Төслөөс мөнгө авна гэдэг тийм ч амаргүй байсан. Со багш тулдаа бүтээсэн байх гэж бодоод өнгөрсөн. Бид энэ ажлаа үргэлжлүүлэн явуулж өнгөрсөн онд болрын кристалл дахь радиацийн дефектийн талаар эрдэм шинжилгээний хоёр өгүүлэл нийтлүүлсэн билээ. Одоо бидний өмнө Со багшийнхаа эхэлсэн энэ ажлыг цаашид хэрхэн авч явж хөгжүүлэх вэ? гэдэг амаргүй асуулт тулгарч байна.

ХОЁР ДАХЬ ДУРСАМЖ

Дамбасүрэн багшийг Грассманы хувиргалтыг онолын физикт амжилттай хэрэглэх зам нээлээ гээд физикчдийн дунд шуугиан болж байсан цаг. Нэг удаа Дамбасүрэн багш Физик Технологийн Хүрээлэнгийн семинарт илтгэлээ. Семинар дууссаны дараа энэ хувиргалтын ид шидийн тухай хэсэг ярилцав. Гэтэл Со багш би та нарт нэг анекдот ярьж өгье гээд дараах түүхийг ярьсан юм.

*Гурван туршилч ба нэгэн онолчийн паян
/МУҮИС-ийн Дамбасүрэн багшид зориулсан шог үлгэр/*

Туршилч гурван хүүтэй Туршилчийнх гэдэг нэг айл байжээ. Эцэг нь өтлөөд насан өөд болохынхоо өмнө гурван хүүдээ мал хөрөнгөө хувааж аваарай гэж гэрээслэжээ. Ахмад хүүд бүх малын тэн хагасыг, түүнээс үлдсэн малын хагасыг дунд хүүд, түүнээс үлдсэн малын хагасыг бага хүүд өгөхөөр хуваажээ. Хөвгүүд энэ ёсоор малаа хуваасаар байтал адуун дээрээ очоод гацжээ. Тэднийх 11 адуутай юмсанж. 11 нь 2 буюу 4, эсвэл 6-д хуваагдахгүй тул туршилч гурван хүү учраа олж ядан байхад нь Гараасман гэдэг морио унаад замаар явж байсан Дамба гэдэг онолч тэднээс юу болсныг асуужээ. Тэдний учир явдлыг сонсоод Дамба онолч хэлжээ.

- За, та нар миний энэ морийг өөрсдийнхөө моридтой нийлүүлээд адуугаа хувааж ав гэжээ. Тэгээд туршилч гурван хүү адуугаа 12 болгоод ахмад нь 6, дундах нь 3, бага хүү нь 2 адуу

аваад салжээ. Харин нэг морь илүү гараад байхаар нь онолчи эргүүлэн өгчээ. Тэгээд цөмөөрөөр амар сайхандаа жаргаж гэнэ.

Тэгж байтал бид "Физик боловсрол" сэтгүүлийн нэг дугаарыг гаргах болоод физикчдийн тухай хөгжөөнтэй, наргиантай зүйл хэвлэх болов. Тэгээд энэ шог яриаг Со багшаар өөрөөр нь бичүүлж "Физик боловсрол" сэтгүүлийн 1995 оны 7-т хэвлэж гаргасан юм.

Хожим нь үүнийг Дамбасүрэн багш үзээд Со багш настай хүн гэхэд онолын ийм нарийн зүйлийг сонирхож ойлгож аваад уйгагүй ийм юм бичиж байдаг айхтар хүн шүү гэхэд би ч бас үнэхээр тийм юм гэж бодсон. Энэ хоёрхон жижиг жишээнээ үзэхэд Со багш шинжлэх ухаанд үнэнхүү бие сэтгэлээ зориулсан алив ажлыг зохион байгуулах нарийн арга барилтай, хүний арга эвийг олохдоо гаргуун, хүмүүсийг ажиллуулах эв дүйг сайн олдог, хүний хийсэн ажлыг үнэлж урам хайрлаж дэмжиж тусалж байдаг, юмны шог хошин талыг нь мэдэрдэг тийм нэгэн байсан юм. Со багшийн энэ сайхан чанарууд бид бүхэнд үргэлж үлгэр дуурайл болж байх болно.

У
х
б
я
У
т
х
А
о
б
б
ц

х
а
а
э
а
х
т
а
с
с
с
л
л
а